



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/195-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)  
Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК  
Захирал: Х.Ариунзул  
Утас: 99077062 Цахим хаяг: [ikhayadaudit@gmail.com](mailto:ikhayadaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ</b>	<b>2</b>
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>4</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b>	<b>11</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b>	<b>15</b>
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b>	<b>18</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b>	<b>18</b>

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БЕГ</b>	Боловсролын ерөнхий газар
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>НБББББ</b>	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>МУЕА</b>	Монгол улсын ерөнхий аудитор
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
А.БАТЗАЯА ТАНАА

2024.09.23 № СЭА-2024/189/НЯ-СТА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 5 дугаар түвшинд үнэлэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Тус сургуулийн мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа боловсролын байгууллагын онцлогт тохирохгүй байна.

018020242

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 89.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>236,356,456.17</b>	<b>387,801,951.08</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	137,333,883.53	246,270,263.70
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	137,333,883.53	246,270,263.70
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	137,333,883.53	246,270,263.70
31211	Төрийн сангийн харилцах	137,333,883.53	246,270,263.70
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6,308,482.00	6,384,808.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,461,332.00	3,537,658.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,847,150.00	2,847,150.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	92,714,090.64	135,146,879.38
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	92,714,090.64	135,146,879.38
35420	Аж ахуйн материал	92,714,090.64	134,633,179.38
35470	Бусад хангамжийн материал	-	513,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,002,227,630.24</b>	<b>1,981,708,496.18</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,002,227,630.24	1,981,708,496.18
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,922,348,046.67	1,901,922,662.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,602,742,177.53	1,608,986,177.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(159,832,896.54)	(204,165,805.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,363,413.74)	(10,443,770.94)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	357,188,213.90	453,340,946.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(91,873,170.08)	(161,803,068.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	225,575,963.68	247,830,963.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(108,976,436.32)	(137,559,433.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,159,911.00	55,159,911.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(843,216.00)	(7,099,007.04)
39217	Ном	37,008,413.24	43,113,247.94
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	79,879,583.57	79,785,833.61
39301	Программ хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(360,416.43)	(454,166.39)
39303	Бусад биет бус хөрөнгө	79,690,000.00	79,690,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,238,584,086.41</b>	<b>2,369,510,447.26</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>3,239,080.29</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	3,239,080.29
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	3,239,080.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,958,880.29
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,280,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,238,584,086.41</b>	<b>2,366,271,366.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,238,584,086.41	2,366,271,366.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,035,463,087.36	1,035,463,087.36
51101	Өмч: - төрийн	1,035,463,087.36	1,035,463,087.36
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	28,393,654.36	156,080,934.92
51210	Өмнөх үеийн үр дүн	28,393,654.36	28,393,654.36

51220	Тайлант үеийн үр дүн	-	127,687,280.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,174,727,344.69	1,174,727,344.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,238,584,086.41</b>	<b>2,369,510,447.26</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,961,623,878.80</b>	<b>2,329,293,676.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,792,100.00</b>	<b>10,032,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,792,100.00	10,032,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,641,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,641,000.00
120009	Бусад орлого	4,792,100.00	6,391,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,956,831,778.80</b>	<b>2,319,260,776.24</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,738,921,100.00	2,082,728,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,082,728,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,738,921,100.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	250,000.00	4,248,628.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,248,628.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	217,660,678.80	232,283,248.24
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	217,660,678.80	232,283,248.24
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,864,355,222.84</b>	<b>2,314,328,152.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,864,355,222.84</b>	<b>2,314,328,152.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,747,668,722.84	2,202,660,652.12
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,194,847,751.00	1,461,430,629.35
210101	Үндсэн цалин	835,182,874.00	1,039,096,246.35
210102	Нэмэгдэл	296,950,606.00	360,946,598.00
210104	Урамшуулал	62,714,271.00	61,387,785.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	148,832,578.27	183,163,334.77
210201	Тэтгэврийн даатгал	101,227,306.46	124,717,822.28
210202	Тэтгэмжийн даатгал	11,922,098.07	14,672,684.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,341,226.36	13,065,287.95
210204	Ажилгүйдлийн даатгал	2,302,382.85	2,781,214.79
210205	Эрүүл мэндийн даатгал	23,039,564.53	27,926,325.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	163,843,831.00	203,890,863.24
210301	Гэрэл, цахилгаан	21,857,300.00	29,732,507.24
210302	Түлш, халаалт	127,813,331.00	161,102,356.00
210303	Цэвэр, бохир ус	14,173,200.00	13,056,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,230,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,230,000.00	-

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	77,005,414.00	91,675,200.00
210502	Хоол, хүнс	77,005,414.00	91,675,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,523,200.00	22,327,385.00
210604	Урсгал засвар	14,523,200.00	22,327,385.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	15,580.00
210702	Дотоод албан томилолт	-	15,580.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,591,975.00	16,054,510.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,792,100.00	6,041,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,799,875.00	10,012,610.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	125,793,973.57	224,103,149.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,402,934.00	52,862,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,883,312.00	19,965,248.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,507,727.57	151,275,701.76
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	116,686,500.00	111,667,500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	116,686,500.00	111,667,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	116,686,500.00	111,667,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>97,268,655.96</b>	<b>14,965,524.12</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>97,268,655.96</b>	<b>14,965,524.12</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,961,623,878.80</b>	<b>2,329,293,676.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,792,100.00</b>	<b>10,032,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,792,100.00	10,032,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,641,000.00
1200041	Үнэгүй үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,641,000.00
120009	Бусад орлого	4,792,100.00	3,641,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,956,831,778.80</b>	<b>2,319,260,776.24</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,738,921,100.00	2,082,728,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,082,728,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,738,921,100.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	250,000.00	4,248,628.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,248,628.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	217,660,678.80	232,283,248.24
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	217,660,678.80	232,283,248.24
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,773,706,995.27</b>	<b>2,183,224,896.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,773,706,995.27</b>	<b>2,183,224,896.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,657,020,495.27</b>	<b>2,072,843,096.07</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,194,847,751.00	1,459,488,865.28
210101	Үндсэн цалин	835,182,874.00	1,088,131,428.96
210102	Нэмэгдэл	296,950,606.00	311,285,064.32
210104	Урамшуулал	62,714,271.00	60,072,372.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	148,832,578.27	183,222,544.55
210201	Тэтгэврийн даатгал	101,227,306.46	126,080,034.27
210202	Тэтгэмжийн даатгал	11,922,098.07	13,395,329.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,341,226.36	11,892,623.26
210204	Ажилгүйдлийн даатгал	2,302,382.85	3,203,811.20
210205	Эрүүл мэндийн даатгал	23,039,564.53	28,650,746.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	163,843,831.00	203,890,863.24
210301	Гэрэл, цахилгаан	21,857,300.00	29,732,507.24
210302	Түлш, халаалт	127,813,331.00	161,102,356.00
210303	Цэвэр, бохир ус	14,173,200.00	13,056,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	77,005,414.00	91,675,200.00
210502	Хоол, хүнс	77,005,414.00	91,675,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	435,200.00	28,392,385.00
210604	Урсгал засвар	435,200.00	28,392,385.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	15,580.00
210702	Дотоод албан томилолт	-	15,580.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,966,275.00	17,416,010.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,792,100.00	6,041,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,174,175.00	11,374,110.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	57,089,446.00	88,741,648.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,799,434.00	68,576,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,290,012.00	20,165,248.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>116,686,500.00</b>	<b>110,381,800.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	116,686,500.00	110,381,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	116,686,500.00	110,381,800.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>187,916,883.53</b>	<b>146,068,780.17</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>50,583,000.00</b>	<b>37,132,400.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>50,583,000.00</b>	<b>37,132,400.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	50,583,000.00	37,132,400.00
222001	Тоног төхөөрөмж	50,583,000.00	37,132,400.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(50,583,000.00)</b>	<b>(37,132,400.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>137,333,883.53</b>	<b>108,936,380.17</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	137,333,883.53
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>137,333,883.53</b>	<b>246,270,263.70</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	1,035,463,087.36	1,174,727,344.69	(319,335,443.16)	1,890,854,988.89
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,884,546,506.89)	(1,884,546,506.89)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,035,463,087.36	1,174,727,344.69	(2,203,881,950.05)	6,308,482.00
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,232,275,604.41	2,232,275,604.41
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	1,035,463,087.36	1,174,727,344.69	28,393,654.36	2,238,584,086.41
НББ-ийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,035,463,087.36	1,174,727,344.69	28,393,654.36	2,238,584,086.41
ҮХ-ийн өсөлт, бууралт	-	-	-	-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	127,687,280.56	127,687,280.56
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	1,035,463,087.36	1,174,727,344.69	156,080,934.92	2,366,271,366.97

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,470,050,300.00	2,220,357,296.07	249,693,003.93	89.9
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,470,050,300.00	2,220,357,296.07	249,693,003.93	89.9
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,333,364,400.00	2,109,975,496.07	223,388,903.93	90.4
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,645,211,500.00	1,459,488,865.28	185,722,634.72	88.7
210101	Үндсэн цалин	446,717,800.00	372,004,491.32	74,713,308.68	83.3
210102	Нэмэгдэл	1,120,637,300.00	1,027,412,001.96	93,225,298.04	91.7
210104	Урамшуулал	77,856,400.00	60,072,372.00	17,784,028.00	77.2
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	205,651,500.00	183,222,544.55	22,428,955.45	89.1
210201	Тэтгэврийн даатгал	139,842,900.00	126,080,034.27	13,762,865.73	90.2
210202	Тэтгэмжийн даатгал	16,452,100.00	13,395,329.26	3,056,770.74	81.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,161,700.00	11,892,623.26	1,269,076.74	90.4
210204	Ажилгүйдлийн даатгал	3,290,500.00	3,203,811.20	86,688.80	97.4
210205	Эрүүл мэндийн даатгал	32,904,300.00	28,650,746.56	4,253,553.44	87.1
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	209,454,800.00	203,890,863.24	5,563,936.76	97.3
210301	Гэрэл, цахилгаан	28,788,300.00	28,550,207.24	238,092.76	99.2
210302	Түлш, халаалт	166,493,200.00	161,102,356.00	5,390,844.00	96.8
210303	Цэвэр, бохир ус	14,173,300.00	14,238,300.00	(65,000.00)	100.5
2105	<b>Нормативт зардал</b>	96,441,000.00	91,675,200.00	4,765,800.00	95.1
210502	Хоол, хүнс	96,441,000.00	91,675,200.00	4,765,800.00	95.1
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	28,392,600.00	28,392,385.00	215.00	100.0
210604	Урсгал засвар	28,392,600.00	28,392,385.00	215.00	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	200,000.00	166,280.00	33,720.00	83.1
210702	Дотоод албан томилолт	200,000.00	166,280.00	33,720.00	83.1
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	19,384,900.00	17,686,010.00	1,698,890.00	91.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,041,900.00	6,041,900.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,343,000.00	11,644,110.00	1,698,890.00	87.3
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	91,495,700.00	88,320,948.00	3,174,752.00	96.5

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,330,400.00	68,155,700.00	3,174,700.00	95.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,165,300.00	20,165,248.00	52.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	136,685,900.00	110,381,800.00	26,304,100.00	80.8
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	136,685,900.00	110,381,800.00	26,304,100.00	80.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	136,685,900.00	110,381,800.00	26,304,100.00	80.8
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>37,132,400.00</b>	<b>37,132,400.00</b>	-	<b>100.0</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	37,132,400.00	37,132,400.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,470,050,300.00</b>	<b>2,333,542,304.24</b>	<b>136,507,995.76</b>	<b>94.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,082,728,900.00	2,082,728,900.00	-	
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,082,728,900.00	2,082,728,900.00	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	12,140,200.00	14,281,528.00	(2,141,328.00)	117.6
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,241,900.00	10,032,900.00	(3,791,000.00)	160.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,898,300.00	4,248,628.00	1,649,672.00	72.0
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	237,847,400.00	232,283,248.24	5,564,151.76	97.7
132001	Орон нутгийн төсвөөс	237,847,400.00	232,283,248.24	5,564,151.76	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		<b>137,333,883.53</b>	<b>(137,333,883.53)</b>	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		<b>246,270,263.70</b>	<b>(246,270,263.70)</b>	
<b>6</b>	<b>Урьд оны үлдэгдлээс</b>	137,333,800.00	-	-	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	82	82	-	100.0
620001	Удирдах ажилтан	5	5	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	56	56	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	21	21	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь "Хүүхдийн хөгжлийг тасралтгүй дэмжих, хичээл сургалтын үйл ажиллагааг хосолсон хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулж хоцрогдлыг нөхөх, арилгахад бүх талын оролцоог дэмжин ажиллах" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагч бүрийг боловсролд тэгш хамруулах, сургууль завсардахаас сэргийлэх, "Ногоон гэрэл" хөтөлбөрийг үр дүнтэй хүртээмжтэй хэрэгжүүлэх;
- Хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж цахим хичээлийн болон даалгаврын сан бүрдүүлэн ашиглах;
- Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүй, мэдлэг ур чадвараа хөгжүүлж, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх;
- Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Мэргэжил, арга зүйн байгууллага болон мэргэжлийн бүлгээр хамтран ажиллаж, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэн сургалт үйл ажиллагааны чанарыг сайжруулах;
- Ажлын байран дээрх эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бэхжүүлэх;
- Багш, ажилтны хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*

*“ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”;  
гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,369,510.4 мянган төгрөг болж өмнөх оноос 130,926.3 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	137,333.9	246,270.3	108,936.4
Авлага	6,308.5	6,384.8	76.3
Бараа материал	92,714.1	135,146.9	42,432.8
Үндсэн хөрөнгө	2,002,227.6	1,981,708.5	(20,519.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,238,584.1</b>	<b>2,369,510.4</b>	<b>130,926.3</b>
Өр төлбөр	-	3,239.1	3,239.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,238,584.1	2,366,271.4	127,687.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,238,584.1</b>	<b>2,369,510.4</b>	<b>130,926.3</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 246,270.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасангай холбоотой байна.
- Авлага дансны эцсийн үлдэгдэлд 6,384.8 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан нь өмнөх оны барагдуулаагүй авлагын 2,847.2 мянган төгрөг, тайлант онд шинээр үүссэн 3,537.6 мянган төгрөгийн ажилчидтай холбоотой авлагатай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 135,146.9 мянган төгрөг болж 42,432.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 263,945.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 25,886.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 260,834.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас голлон шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,981,708.5 мянган төгрөг болж 20,519.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдэлтэй холбоотой байна.
- Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 3,239.1 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь тайлант онд худалдан авсан хоол хүнсний материалын 1,280.2 мянган төгрөг, ажилчидтай холбоотой өглөгийн 1,958.9 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүссэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,397,330.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 237,847.4 мянган төгрөг нийт **2,635,178.0** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын өөрчлөлтгүй баталсан байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 314,601.9 мянган төгрөг болгон бууруулж **2,082,728.9** мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 12,140.2 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 137,333.8 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 237,847.4 мянган төгрөгөөр, нийт **2,470,050.1** эцэслэн баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,082,728.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогыг 12,140.2 мянган төгрөг, урьд оны санхүүжилтээс 137,333.8 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 237,847.4 мянган төгрөгөөр, нийт **2,470,050.1** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд **2,220,357.3** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,220,357.3** мянган төгрөг буюу **89.9** хувьтай байгаа байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 185,722.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 22,429.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,563.9 мянган төгрөгөөр, норматив зардлыг 4,765.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.2 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 33.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 1,698.9 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 3,174.8 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг зардлыг 26,304.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
<b>71802 – Ерөнхий боловсрол</b>					
1	Байр ашиглалтын үйлчилгээ	5,337.2	5,337.2	-	100.0
2	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	3,220.0	644.0	2,576.0	20.0
3	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	12,371.4	12,371.4	-	100.0
4	Боловсролын стандарт, сургалт	1,585,203.1	1,394,763.2	190,439.9	88.0

5	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	550.0	166.3	383.7	30.2
6	Дотуур байрны үйлчилгээ	149,854.5	137,737.5	12,117.0	91.9
7	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	150.7	150.6	0.1	100.0
8	Сурах бичгийн түрээс	6,041.9	6,041.9	-	100.0
9	Сургалт семинар	5,201.7	5,201.7	-	100.0
10	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	264,642.6	255,519.3	9,123.3	96.6
11	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	237,847.4	232,283.2	5,564.2	97.7
12	Үдийн цай хөтөлбөр	136,685.9	110,381.8	26,304.1	80.8
13	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	56,639.1	53,814.4	2,824.7	95.0
14	Эрүүл мэндийг дэмжих	6,304.8	5,944.8	360.0	94.3
	<b>ДҮН</b>	<b>2,470,050.3</b>	<b>2,220,357.3</b>	<b>249,693.0</b>	<b>89.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнс худалдан авах 96,441.0 мянган төгрөг төсөв батлагдсан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг [tender.gov.mn](http://tender.gov.mn) цахим сайтад байршуулж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны шалгаруулалтад "Ноён уулын хишиг" ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Их наяд аудит" ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,864,355.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,643.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 28 төрлийн 159 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулжээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн дагуу мөнгөн гүйлгээний мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, үнэн зөв, бүрэн байршуулах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

##### 1. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 30,125.1 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснийг залруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,825.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга хийгээгүй, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон зэрэг зөрчилд 3 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж шилэн дансны 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй тул 66.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага					
Зөвлөмж	3	3,825.7	2	3,825.7	66.7
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>3,825.7</b>	<b>2</b>	<b>3,825.7</b>	<b>66.7</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “**Зөрчилгүй**”, “ **Итгэл үзүүлсэн**”, “**Түүвэрт хамрагдсан**” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу **947.7** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Ж.Цэвээнсүрэнд 947.7 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

3. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 30,125.1 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ 11,819.6 мянган төгрөгийн цахим баримтыг дутуу бүрдүүлсэн.
2. Цалингийн зардал, түүнтэй холбоотой 15,153.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг журналд тусгахдаа мөнгөн сууриар хөтөлж, зөрүүтэй бүртгэж тайлагнасан.
3. Цалингийн хүснэгтээрх тооцсон цалинг нийгмийн даатгалын тайланд 3,151.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгаж тайлагнасан.
4. Авлага, өр төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.

Аудитаар нийт 10,775.3 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илрүүлж, 1 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өглөө.

## **5.1 Албан шаардлага**

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас ажиллагсадтай холбоотой 3,537.2 мянган төгрөгийн авлага, хүнсний материалын 1,280.2 мянган төгрөгийн, ажиллагсадтай холбоотой 1,958.9 мянган төгрөгийн өр төлбөр тус тус үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

## **5.1 Зөвлөмж**

### **1. Бараа материалын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Хангамжийн материал дансанд бүртгэх 1,151.8 мянган төгрөгийн бараа материалыг бичиг хэргийн материалд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн Үнэн зөв байх зарчмыг баримтална." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэл тооцоог хянан баталгаажуулан бүртгэл тайланд үнэн зөв тусгаж ажиллах.

### **1. Цалингийн данстай холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 5,734.2 мянган төгрөгийн цалин дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 дахь "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулж, бодогдсон цалинг НДШ-ийн тайланд үнэн зөв тусгаж тайлагнах.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлан дахь өмнөх оны үлдэгдэл 2,847.2 мянган төгрөгийн үдийн цайны хөтөлбөртэй холбоотой актын төлбөрийг БШУЯ-д төлснөөс үүссэн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй, авлага барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Авлага барагдуулах ажлыг зохион байгуулж, үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ цахим баримтыг дутуу бүрдүүлсэн.	1	11,819.6			1	11,819.6	1	11,819.6				
Цалингийн зардал, түүнтэй холбоотой ажил гүйлгээг журналд тусгахдаа мөнгөн сууриар хөтөлж, зөрүүтэй бүртгэж тайлагнасан.	1	15,153.8			1	15,153.8	1	15,153.8				
Цалингийн хүснэгтээрх тооцсон цалинг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тусгаж тайлагнасан.	1	3,151.7			1	3,151.7	1	3,151.7				
Авлага, ер төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.	1	-			1	-	1	-				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>30,125.1</b>			<b>4</b>	<b>30,125.1</b>	<b>4</b>	<b>30,125.1</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Үүнээс										/мянган төгрөгөөр/	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн.	1	6,776.3			1	6,776.3						
Бараа материалыг буруу бүртгэж тайлагнасан.	1	1,151.8					1	1,151.8				
Өмнөх оны авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	2,847.2					1	2,847.2				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>10,775.3</b>			<b>1</b>	<b>6,776.3</b>	<b>2</b>	<b>3,999.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Үүнээс										/мянган төгрөгөөр/	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1						1					
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
<b>Дүн</b>												
<b>Нийт дүн</b>	<b>1</b>						<b>1</b>					